



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 01/409

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/1063 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/1063 дугаар захирамжийн дагуу “Буянт-Ухаа 1” орон сууцны хорооллоос хуваарилсан нийслэлийн нутгийн захиргааны 30 албан хаагчтай байгуулсан “Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад орон сууц худалдах гэрээ”-г дүгнэх үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулж, үр дүнг 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг /С.Сэржжаргал/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад үүрэг болгосугай.


~~ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ~~



Ш.ҮНЭНБАТ

115050000967

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны ...~~09~~ дугаар сарын ~~29~~... өдрийн  
~~01/4/20~~... дугаар тушаалын хавсралт



### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

С.Сэржжаргал Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Цолмон Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Цэрэндулам Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Батбаяр Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн нярав

Нарийн бичгийн дарга:

А.Эрдэнэмөнх Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн